



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 25

Мандалговь

**Хөрөнгө акталж худалдах тухай**

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Г.Тувааны нэрэмжит Нэгдсэн эмнэлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 40,954,500 /Дөчин сая есөн зуун тавин дөрвөн мянга таван зуун төгрөг/-ний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 49-97 ДУА улсын дугаартай Донг пэнг маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 2.000,000.00 /Хоёр сая төгрөг/-өөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг . Г.Тувааны нэрэмжит Нэгдсэн эмнэлэгийн дарга /Х.Жаргал /-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР